Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх, чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.2.1.төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх;

4.1.2.2.зөвшөөрөл олгох журмыг хялбарчилж, түүнд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх, зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх;

4.1.2.3.олон улсын стандарт хангасан бараа, бүтээгдэхүүнийг дотоодын стандартаар шалгадаг зохицуулалтыг өөрчлөх, шаардлагагүй стандартыг хүчингүй болгох;

4.1.2.4.эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох;

4.1.2.5.төрийн үйлчилгээний шударга, ил тод, нээлттэй байдлын талаархи судалгааг тогтмол хийж, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглах;

4.1.2.6.өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл, гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх;

4.1.2.7.төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах.

4.1.3.Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, хариуцлагыг дээшлүүлэх

Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.3.1.улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх;

4.1.3.2.төсвийн төлөвлөлтийн үр ашигтай байдал, гүйцэтгэл, зарцуулалтын хөндлөнгийн хяналт, хариуцлагыг дээшлүүлэх;

4.1.3.3.Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох;

4.1.3.4.төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах;

4.1.3.5.банк, санхүүгийн байгууллагын санхүү, зээлийн бодлогыг боловсронгуй болгож, давуу байдлаа ашиглан иргэн, аж ахуйн нэгжид хүндрэл учруулдаг байдлыг таслан зогсоох;

4.1.3.6.нийтийн албаны санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтын үйл

ажиллагаа, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох;

4.1.3.7.аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлагын тогтолцоог сайжруулах;

4.1.3.8.аудитын үйл ажиллагааг хараат бус, хуулийн дагуу гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, шаардлагатай зарим тохиолдолд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаад улсын аудитын хуулийн этгээдийг ажиллуулах эрх зүйн орчинг бий болгох;

4.1.3.9.төрийн аудитын байгууллагын хараат бус байдал, чадавхийг бэхжүүлэн аудитын чанар, үр нөлөөг дээшлүүлж, авлигаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг хангахад дэмжлэг үзүүлэх;

4.1.3.10.төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг олон нийтэд ил тод мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгож, нийтийн алба, албан тушаалтны үйл ажиллагаа, түүний үр дүнг иргэд, олон нийтийн хяналтад оруулах.

4.1.4.Худалдан авах ажиллагааны хяналт, хариуцлага, үр ашгийг нэмэгдүүлэх

Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.4.1.тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх;

4.1.4.2.тендер шалгаруулалтын талаар гарсан гомдлыг хянан шийдвэрлэх журмыг шинэчлэх, гаргасан шийдвэр, дүгнэлтийг олон нийтэд ил тод болгох;

4.1.4.3.худалдан авах ажиллагааны бодлого, төлөвлөлтийг сайжруулж, ил тод болгох, олон нийтээр урьдчилан хэлэлцүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх;

4.1.4.4.концесс, гэрээ шууд байгуулах аргачлал, шалгуурыг тодорхой болгох;

4.1.4.5.санхүүгийн үйл ажиллагаан дахь хөндлөнгийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх, гэрээний үүргээ биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг дээшлүүлэх.

4.1.5.Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах

Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах зорилтыг хангах чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.5.1.шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төрийн нам, бүлгээс хараат бус ажиллах, шүүгч, прокурорыг сонгон шалгаруулах, томилох үйл явцыг улс төрийн оролцоо, нөлөөллөөс ангид, шударга, ил тод явуулах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

4.1.5.2.шүүхийн удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулах журмыг бүх шатанд нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх;

4.1.5.3.шүүгч, прокурорын сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх;

4.1.5.4.авлига, албан тушаалын гэмт хэргийн шийдвэрлэлтийн мэдээлэлд дүгнэлт хийх тогтолцоог бүрдүүлэх, энэ талаархи эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

4.1.5.5.цахим сүлжээг ашиглах, байнгын ажиллагаатай утас ажиллуулах замаар авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн талаархи мэдээллийг авах, мэдээлэл өгч байгаа иргэнийг урамшуулах тогтолцоог бүрдүүлэх;

4.1.5.6.мэдээлэл өгч байгаа иргэн, сэтгүүлчийг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэх;

4.1.5.7.авлигатай тэмцэх байгууллагын чадавхийг бэхжүүлэх;

4.1.5.8.авлигын эсрэг үйл ажиллагаанд мэдээллийн орчин үеийн технологийг ашиглах, авлига, албан тушаалын гэмт хэргийн илрүүлэлтэд шинжлэх ухаан,

технологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх;

4.1.5.9.авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтэд тавих олон нийтийн хяналтыг сайжруулах зорилгоор хууль сахиулах байгууллагыг нэгдсэн мэдээллийн сантай болгох;

4.1.5.10.үйлдэгдэж байгаа авлига, албан тушаалын гэмт хэрэг болон түүний шийдвэрлэлтийн талаар хуульд заасан үндэслэл, журмын дагуу олон нийтэд тогтмол мэдээлэх;

4.1.5.11.хууль сахиулах байгууллагын алба хаагчийн авлига, албан тушаалын гэмт хэргийг олж илрүүлэх, мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх талаархи мэдлэг туршлага, ур чадварыг сайжруулах;

4.1.5.12.хууль сахиулах байгууллагын алба хаагчийн давтан сургалтын хөтөлбөрийн агуулгад авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэх асуудлыг тусгаж, хэрэгжүүлэх;

4.1.5.13.хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах үүрэг бүхий албан тушаалтны хүрээг оновчтой тогтоож, мөрдөх;

4.1.5.14.хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягтыг боловсронгуй болгож, мэдүүлгийг цахим хэлбэрээр хүлээн авах тогтолцоонд бүрэн шилжүүлэх;

4.1.5.15.аливаа хууль бус нөлөөлөл, түүний хэлбэрүүдийг тодорхойлж, түүнд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох;

4.1.5.16.хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөлд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр санал, зөвлөмж гаргах тогтолцоог бүрдүүлэх;

4.1.5.17.хахууль өгсөн хүн эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, зарим нэр томъёог хуульчлан тодорхойлох.

4.1.6.Хувийн хэвшил дэх авлигын эрсдэлийг бууруулах, өрсөлдөөний шударга байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх

Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтыг хангах чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.6.1.хувийн хэвшлийн байгууллагуудын авлигын эсрэг сүлжээний үйл ажиллагааг дэмжих, дэлхийн эдийн засгийн форумын авлигын эсрэг түншлэлийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх;

4.1.6.2.хувийн хэвшлийн байгууллагуудыг чадавхжуулж, төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх боломжийг судлан хэрэгжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн заагийг тодорхойлох;

4.1.6.3.төр, хувийн хэвшлийн болон хувийн хэвшил хоорондын авлигаас урьдчилан сэргийлэх хамтын ажиллагааг өргөжүүлж, аливаа санал, санаачилгыг дэмжиж, хамтран ажиллах;

4.1.6.4.картель, шударга бус өрсөлдөөнийг хязгаарласан эрх зүйн орчинг сайжруулах;

4.1.6.5.олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах.

4.1.7.Иргэний нийгмийн байгууллагын идэвх санаачилга, оролцоог дэмжих

Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилтыг хангах чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.7.1.төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, батлах зэрэг шийдвэр гаргах бүх шатанд тухайн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулах замаар авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэхэд иргэний нийгмийн байгууллагын оролцоог дэмжих;

4.1.7.2.төрийн бус байгууллагын үйл ажиллагаа, санхүүжилтийг ил тод, нээлттэй

болгох чиглэлээр Төрийн бус байгууллагын тухай хуулийг боловсронгуй болгох;

4.1.7.3.төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх;

4.1.7.4.орон нутгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон яам, агентлагийн дэргэд авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг байгуулан ажиллуулах;

4.1.7.5.авлигатай тэмцэх газрын дэргэдэх олон нийтийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх;

4.1.7.6.авлигын улмаас төр, иргэн, олон нийтийн эрх ашигт эдийн засгийн хохирол учруулсан бол тухайн этгээдийн өмчийн хэлбэрийг харгалзахгүйгээр хохирлыг нөхөн төлүүлэх талаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг төрийн бус байгууллагад олгох, уг нэхэмжлэлийг улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх эрх зүйн зохицуулалтыг бий болгох, авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгахад мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын туслалцааг авах.

4.1.8.Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх

Иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.8.1.хэвлэл мэдээллийн байгууллагын мэдээлэл олж авах, түгээх эрхийг баталгаажуулах;

4.1.8.2.эрэн сурвалжлах замаар авлига, албан тушаалын гэмт хэргийн талаар мэдээлсэн сэтгүүлчийг аливаа дарамт, шахалтаас хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох, сэтгүүлчийг мэргэжлийн үйл ажиллагааных нь улмаас эрүүгийн хариуцлагад татах явдлыг өөрчилж, аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг бий болгох;

4.1.8.3.хэвлэл мэдээллийн байгууллагын бие даасан, хараат бус байдал, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэх;

4.1.8.4.төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд аливаа нийтлэл, нэвтрүүлэг, зар сурталчилгаа, мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэхтэй холбоотой үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулах;

4.1.8.5.сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй зөрчсөн асуудлыг хэлэлцэх, холбогдох хариуцлага тооцох чиглэлээр ажиллах Хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах.

4.1.9.Улс төрийн хүрээнд шударга ёсыг бэхжүүлэх

Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төр, бизнесийн бүлэглэлийн хууль бус ашиг сонирхол, нөлөөллөөс ангид байлгах зорилтыг хангах чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.9.1.улс төрийн намын санхүүжилт, түүний тайланг олон нийтэд ил тод, нээлттэй болгох чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгож, хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх, хууль бус санхүүжилт авахгүй байх, сонгуулийн санхүүгийн тайлан гаргах, түүнд хийсэн аудитын дүгнэлтийг мэдээлэх зэрэг үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг нарийвчлан зохицуулах замаар улс төрийн намын санхүүжилтийн үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог сайжруулах, хуульд байгаа зохицуулалтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх;

4.1.9.2.Улсын Их Хуралд суудалтай улс төрийн намын санхүүгийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, мэдээлэх тогтолцоо бүрдүүлэх;

4.1.9.3.төрөөс олгох улс төрийн намын санхүүжилтийг хүртээмжтэй болгож, Улсын Их Хуралд суудалгүй намуудыг төлөвших, санхүүгийн хувьд ашиг сонирхлын

бүлэглэлийн нөлөөнд автахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх;

4.1.9.4. Сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хуулийг боловсронгуй болгох;

4.1.9.5. төрийн өндөр албан тушаалтны ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг сайжруулж, хариуцлага тооцох тогтолцоог бий болгох, авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн, зөрчил гаргасан төрийн өндөр албан тушаалтны эрхийг түдгэлзүүлэх, огцруулах, эгүүлэн татах эрх зүйн орчинг бүрдүүлэх;

4.1.9.6. улс төрийн намын удирдах албан тушаалтны хөрөнгө, орлогын байдалд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх;

4.1.9.7. төрийн бодлого, шийдвэр гаргахад нийгмийн сонирхлын бүлэг, иргэн оролцох, нөлөөлөх /лоббидох/ эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

4.1.9.8. улс төрийн хариуцлагыг дээшлүүлэх, ил тод байдлыг хангахад иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх.

4.1.10. Авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх

Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.10.1. авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх;

4.1.10.2. боловсролын байгууллага болон гэр бүлээр дамжуулан авлигыг үл тэвчих, шударга иргэнийг төлөвшүүлэх зорилгоор олон талт арга хэмжээ зохион байгуулах, авлигын эсрэг боловсрол олгох агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, стандартад тусгах;

4.1.10.3. зорилтот бүлэгт зориулсан сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, авлигыг үл тэвчих хандлагыг бий болгоход чиглэсэн сургалтыг үе шаттай зохион байгуулах, цахим сүлжээг ашиглах;

4.1.10.4. авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;

4.1.10.5. авлигын эсрэг сайн туршлагыг олон нийтэд түгээх.

4.1.11. Олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх

Авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын байгууллагын санал, зөвлөмжийг авч хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.11.1. Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын /цаашид “НҮБ” гэх/ конвенцийг эрх зүйн харилцан туслалцааны үндэслэл болгон хэрэглэх, эрх зүйн харилцан туслалцааны гэрээг бусад улс оронтой байгуулах ажлыг эрчимжүүлэх, дотоодын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;

4.1.11.2. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг хэрэгжүүлэх чиглэлээр НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба болон бусад олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

4.1.11.3. гадаад улсын авлигатай тэмцэх болон хууль сахиулах байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлж, авлига, албан тушаалын гэмт хэргийн улмаас гадаад улсад гарсан хөрөнгийг буцаан авахтай холбоотой асуудлыг нарийвчлан зохицуулах;

4.1.11.4. авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн этгээдийг харилцан шилжүүлэхтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулах;

4.1.11.5. авлигын эсрэг олон улсын сүлжээ, санал санаачилгыг дэмжиж, хамтын ажиллагааг өргөжүүлэх.

Тав. Хөтөлбөрийн хугацаа, үе шат, хүрэх үр дүн

- 5.1.Хөтөлбөрийг 6 жилийн хугацаанд хоёр үе шаттай хэрэгжүүлнэ.
- 5.1.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэг дэх үе шат /2016-2019 он/:
- 5.1.1.1.авлигатай тэмцэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох, нийтийн албанд цогц шинэтгэл хийх үйл ажиллагаа эрчимжсэн байх;
- 5.1.1.2.төрийн байгууллагын авлигын эрсдэлийг үнэлэх ажиллагаа хэвшсэн байх;
- 5.1.1.3.авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ ахисан байх;
- 5.1.1.4.төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлсэн байх;
- 5.1.1.5.шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын авлигын эсрэг хамтын ажиллагаа сайжирсан байх;
- 5.1.1.6.төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлж эхэлсэн байх;
- 5.1.1.7.хувийн хэвшил дэх авлигын эрсдэлийг бууруулж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын хамтын ажиллагаа сайжирсан байх;
- 5.1.1.8.шударга ёсны үзэл санаа нийгэмд төлөвшиж, иргэн өөрт учирч байгаа хүндрэл, бэрхшээлийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлдэг байх нийгмийн сэтгэлгээ, хандлага өөрчлөгдсөн байх;
- 5.1.1.9.хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлага дээшилсэн байх;
- 5.1.1.10.“Транспарэнси Интернэшнл” байгууллагын судалгаагаар Монгол Улсын авлигын төсөөллийн индексийн үзүүлэлт сайжирсан байх;
- 5.1.1.11.төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ сайжирсан байх;
- 5.1.1.12.улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын төсөөлөлд эерэг өөрчлөлт гарсан байх.
- 5.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хоёр дахь үе шат /2020-2023 он/:
- 5.2.1.“Транспарэнси Интернэшнл” байгууллагын судалгаагаар Монгол Улсын авлигын төсөөллийн индексийн үзүүлэлт өмнөх үзүүлэлтээс сайжирсан байх;
- 5.2.2.төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ өмнөх үзүүлэлтээс өссөн байх;
- 5.2.3.улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын төсөөллийн судалгааны дүн сайжирсан байх;
- 5.2.4.төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдал хангагдсан байх;
- 5.2.5.улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг шалгах, мэдээлэгчийг хамгаалахад иргэн хяналт тавих бололцоо бүрдсэн байх;
- 5.2.6.авлигад илүү өртсөн салбаруудын болон өндөр түвшний авлигын гэмт хэрэг, зөрчил гарах шалтгаан нөхцөлийг бууруулсан байх;
- 5.2.7.авлигатай тэмцэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо, хяналт сайжирсан байх;
- 5.2.8.төрийн байгууллагад итгэх иргэний итгэл нэмэгдсэн байх.

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт

- 6.1.Хөтөлбөрийн санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:
- 6.1.1.улсын болон орон нутгийн төсөв;
- 6.1.2.олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламжийн хөрөнгө;
- 6.1.3.бусад эх үүсвэр.

6.2.Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг дарга хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж батлуулна.

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ үнэлгээ, түүний зохион байгуулалт

7.1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, авлигатай тэмцэх байгууллага хөтөлбөрийг дараахь байдлаар хэрэгжүүлнэ:

7.1.1.Улсын Их Хурал хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, хөтөлбөрт тусгагдсан хууль тогтоомжийн төслийг батална;

7.1.2.Монгол Улсын Ерөнхийлөгч хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг ерөнхий удирдлагаар хангана;

7.1.3.Засгийн газар хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр яам, агентлаг, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ;

7.1.4.Авлигатай тэмцэх газрын бүтцэд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын алба /цаашид “Ажлын алба”/ ажиллана. Ажлын алба хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, санал зөвлөмж, аргачлал боловсруулах, хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, бүс нутгийн болон олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, иргэд, олон нийтэд хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар мэдээлэл хүргэх, хэрэгжилтийн байдлыг үнэлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ;

7.1.5.Авлигатай тэмцэх газар хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийн тайланг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд танилцуулна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлалыг Авлигатай тэмцэх газрын дарга баталж, мөрдүүлнэ.

7.2.Үндэсний хөтөлбөрийн мэдээллийн нэгдсэн цахим сан ажиллана.

Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах

8.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагууд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн 02 дугаар сарын 01-ний дотор Ажлын албанд хүргүүлнэ.

8.2.Авлигатай тэмцэх газар тайланг нэгтгэн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэн, санал дүгнэлтээ Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд танилцуулна.

8.3.Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо тайлан, үнэлгээ, санал, дүгнэлтийг хэлэлцэж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зөрчлийг арилгах, ажлаа эрчимжүүлэх талаар чиглэл өгсөн тогтоол гаргаж болно.

8.4.Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл энэхүү хөтөлбөрийн 8.3-т заасан асуудлыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж болно.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2012 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай

Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.7 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.8 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт”-ыг 2 дугаар хавсралтаар, “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн маягт”-ыг 3 дугаар хавсралтаар, “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийн маягт”-ыг 4 дүгээр хавсралтаар, “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”-ыг 5 дугаар хавсралтаар, “Сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт”-ыг 6 дугаар хавсралтаар, “Баталгааны маягт”-ыг 7 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулж 2012 оны 02 дугаар сарын 15-ны дотор Хөрөнгө, орлогын мэдүүлгээ мэдүүлсэн албан хаагчдын “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг шинэчлэн бүртгэх ажлыг 2012 оны 8 дугаар сарын 15-ны дотор зохион байгуулах арга хэмжээ авч ажиллахыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолыг 2012 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУУЛЬ ЗҮИН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Д.ОДБАЯР

Тайлбар: Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 04 дугаар сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолын хавсралтад тус Байнгын хорооны 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 20 дугаар тогтоол, 2017 оны 1 дүгээр сарын 3-ны 1 дүгээр тогтоолын дагуу тус тус оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тусгасан болно.

АЛБАН ТУШААЛТНЫ ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ БОЛОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙГ БҮРТГЭХ, ХЯНАХ, ХАДГАЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийн /цаашид “мэдүүлэг гаргагч” гэх/ хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Мэдүүлэг гаргагч хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (цаашид “мэдүүлэг” гэх)-ээ хуульд заасан хугацаанд, батлагдсан маягтын дагуу үнэн зөв гаргаж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуульд заасан байгууллага, албан тушаалтанд биечлэн болон цахим хэлбэрээр энэ журамд заасны дагуу хүргүүлнэ.

1.3. Мэдүүлэг гаргагч мэдүүлгээ бүртгүүлсний дараа түүний хөрөнгө, орлогод их хэмжээний өөрчлөлт орсон бол энэ тухайгаа Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт заасны дагуу 30 хоногийн дотор мэдэгдэж бүртгүүлнэ.

1.4. Мэдүүлэг гаргагч мэдүүлгээ бүртгүүлсний дараа ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон бол энэ тухай хуульд заасан байгууллага, албан тушаалтанд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

1.5. Мэдүүлэг гаргагч нь ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл бичгээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд нэн даруй хүргүүлнэ.

Хоёр. Мэдүүлэг гаргах, түүнийг бүртгэх, хадгалах

2.1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24.1.1, Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтад тус тус заасны дагуу дараах албан тушаалтан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт гаргаж өгнө:

- 2.1.1. Монгол Улсын Ерөнхийлөгч;
- 2.1.2. Улсын Их Хурлын дарга, дэд дарга, гишүүн;
- 2.1.3. Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, дэд сайд;
- 2.1.4. Улсын ерөнхий прокурор, түүний орлогч;
- 2.1.5. Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд, Дэд ерөнхийлөгч;
- 2.1.6. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга;
- 2.1.7. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга;
- 2.1.8. Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга;
- 2.1.9. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга;
- 2.1.10. Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүн, Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн;
- 2.1.11. Үндэсний статистикийн хорооны дарга;
- 2.1.12. Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүн;
- 2.1.13. Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга;
- 2.1.14. Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүн;
- 2.1.15. Ерөнхий аудитор, түүний орлогч;
- 2.1.16. яамны төрийн нарийн бичгийн дарга;

- 2.1.17. Засгийн газрын агентлагийн дарга;
- 2.1.18. Чөлөөт бүсийн захирагч;
- 2.1.19. Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч;
- 2.1.20. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, Ерөнхий захирал, гишүүн;
- 2.1.21. Засгийн газар, Ерөнхий сайдаас томилогддог бусад албан тушаалтан;
- 2.1.22. Хуульчдын холбооны Ерөнхийлөгч, Тамгын газрын дарга.
- 2.2. Энэ журмын 2.1-д зааснаас бусад албан тушаалтан мэдүүлгээ дараах байгууллага, албан тушаалтанд гаргаж өгнө:
- 2.2.1. Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч Шүүхийн ерөнхий зөвлөлд;
- 2.2.2. Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд;
- 2.2.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, ажлын албаны ажилтан, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, түүний орлогч, баг, хорооны Засаг дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд;
- 2.2.4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргаас томилогддог төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалтан аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт;
- 2.2.5. Төрийн захиргааны болон төрийн тусгай албан хаагч, төрийн үйлчилгээний албаны дарга, захирал, эрхлэгч, тэдгээртэй адилтгах албан тушаалтан түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтанд;
- 2.2.6. Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, банк, санхүүгийн байгууллага, биржийн удирдах албан тушаалтан Төрийн өмчийн хороонд /Эдгээр хуулийн этгээдийн удирдах албан тушаалд ажиллаж байгаа гадаадын иргэн нэгэн адил хамаарна/;
- 2.2.7. Монгол Улсаас бусад улстай байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын Засгийн газраас хөрөнгө оруулагчтай байгуулсан тогтвортой байдлын гэрээгээр үйл ажиллагаа нь зохицуулагдаж байгаа төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан Төрийн өмчийн хороонд /Эдгээр хуулийн этгээдийн удирдах албан тушаалд ажиллаж байгаа гадаадын иргэн нэгэн адил хамаарна/;
- 2.2.8. Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмч давамгайлсан аж ахуйн нэгжийн захирал тухайн шатны Засаг даргын Тамгын газарт;
- 2.2.9. Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зорилгоор улсын нэгдсэн төсвөөс төвлөрүүлсэн хөрөнгө, түүнчлэн уг арга хэмжээнд зориулан олгосон хандив, буцалтгүй тусламжийг захиран зарцуулж байгаа Засгийн газрын тусгай сангийн удирдах албан тушаалтан түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтанд /Олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу зээл, тусламж, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн зохицуулагч, удирдах албан тушаалтан нэгэн адил хамаарна/;
- 2.2.10. Эрдэм шинжилгээ, инноваци, туршилт, зохион бүтээх ажлыг дагнан болон сургалт, үйлдвэрлэлтэй хослон гүйцэтгэдэг эрдэм шинжилгээний байгууллагын удирдах албан тушаалтан түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтанд;
- 2.2.11. Яам, агентлагийн дэргэдэх өөрийгөө санхүүжүүлдэг салбар нэгжийн удирдах албан тушаалтан харьяа байгууллагын түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтанд;
- 2.2.12. Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт;
- 2.2.13. Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчтай гэрээ байгуулж, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг түр буюу байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан тухайн төсвийн захирагчид /төсвийн шууд захирагчид/;
- 2.2.14. Төрийн улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийнх нь хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх Улсын Их Хурлын Тамгын газарт;

2.2.15. Улсын Их Хурлын гишүүнээс бусад улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийнх нь хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх, туслах, ажилтан тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтанд.

2.3. Сонгуулийн ерөнхий хороо Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг, сонгуулийн тойргийн хороо Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг, аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо орон нутгийн Хурлын сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг тус тус бүртгэж Сонгуулийн ерөнхий хороонд хүлээлгэн өгнө.

2.4. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгогдсон сонгогдогчдын хөрөнгө, орлогын мэдүүлгийг архивын нэгж болгон тухайн сонгууль дууссанаас хойш 14 хоногийн дотор Авлигатай тэмцэх газарт ирүүлнэ.

2.5. Мэдүүлэг гаргагч мэдүүлгээ шуудангаар илгээх бол эрх бүхий албан тушаалтны нэр дээр “гарт нь” гэж хаяглан баталгаат шуудангаар ирүүлэх бөгөөд энэ тохиолдолд мэдүүлэг гаргасан хугацааг илгээмж дээрх шуудангийн тэмдэглэлийг үндэслэн тооцно.

2.6. Шуудангаар ирсэн мэдүүлгийг тухайн байгууллагын бичиг хэргийн асуудал хариуцсан ажилтан хүлээн авч, илгээмжийг задлалгүйгээр эрх бүхий албан тушаалтанд шууд хүлээлгэн өгнө.

2.6¹. Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим сан (<https://meduuleg.iaac.mn>)-д мэдүүлгээ гаргасан бол үнэн, зөв мэдүүлсэн талаарх баталгааг тухайн байгууллагын мэдүүлгийг хүлээн авах эрх бүхий албан тушаалтанд гаргана.

2.7. Мэдүүлэг гаргагч цахим шуудангаар мэдүүлгээ илгээж болох бөгөөд энэ тохиолдолд хаяг, гарын үсгийн баталгаажилт, нууцлал зэргийг мэдүүлэг хүлээн авах эрх бүхий этгээдтэй урьдчилан тохиролцсон байна.

2.8. Албан тушаалтны мэдүүлэг, мэдүүлгийн бүрдүүлэлтийг цахим хэлбэрээр явуулж болох бөгөөд цахим гарын үсгийг цахим гарын үсгийн тухай хууль тогтоомжоор хэрэгжүүлнэ.

2.9. Мэдүүлгийг цахим хэлбэрээр бүртгэхтэй холбогдсон журмыг Авлигатай тэмцэх газрын дарга Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран батална.

Гурав. Мэдүүлгийг бүртгэж хүлээн авах байгууллага, эрх бүхий албан тушаалтны эрх, үүрэг

3.1. Нийтийн албаны удирдлага нь тухайн байгууллагын захиргаа, хуулийн асуудал эрхэлсэн албаны эрх бүхий албан тушаалтанд мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих, тайлагнах ажлыг тушаал, шийдвэрээр хариуцуулан томилж, түүнд албан тушаалынх нь цалингийн 40 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл урамшуулал олгох бөгөөд шаардлагатай тохиолдолд уг асуудлыг эрхлэх орон тооны ажилтантай байж болно.

3.2. Эрх бүхий албан тушаалтан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хувь хүний нууцтай холбогдох мэдээллийг чандлан хадгалах, хамгаалах бөгөөд нууцын баталгаа гаргана.

3.3. Эрх бүхий албан тушаалтан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуульд заасан хугацаанд мэдүүлгийг авч дууссанаас хойш 14 хоногийн дотор мэдүүлэг гаргах журмын биелэлтийн талаарх тайланг, мэдүүлэг гаргасан этгээдийн нэрсийн хамт Авлигатай тэмцэх газарт ирүүлнэ.

3.4. Мэдүүлгийг бүртгэж хүлээн авч байгаа эрх бүхий албан тушаалтан дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.4.1. Мэдүүлэг засваргүй, бүрэн гүйцэд бөглөгдсөн, хугацаандаа өгсөн эсэхэд хяналт тавьж, мэдүүлгийг зохих журмын дагуу гаргаж өгөхийг шаардах, хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл байвал бүрэн эрхийнхээ хүрээнд хянан шалгах буюу Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулах үүрэгтэй;

3.4.2. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, болон энэ журмын 2.6¹-д заасан баталгаа,

Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг хүлээн авч, бүртгэл хөтлөх бөгөөд хянан шалгах, авлигын шинжтэй зөрчил илэрвэл Авлигатай тэмцэх газарт нэн даруй шилжүүлэх;

3.4.3. Эрх бүхий албан тушаалтан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.2.2 дахь заалт, 8.2, 23.3, 23.5 дахь хэсэг, Авлигын эсрэг хуулийн 10.3, 10.4 дэх хэсэгт тус тус заасны дагуу батлагдсан маягтаар бүртгэл хөтлөх;

3.4.4. энэ журмын 3.4.2-т заасан бүртгэлээс гадна Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт заасан тохиолдолд бүртгэл, хяналт явуулж Авлигатай тэмцэх газарт мэдээлнэ.

3.5. Энэ журмын 3.4.3-т заасан бүртгэлийн маягт, эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журмыг Авлигатай тэмцэх газрын дарга батална.

3.6. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалд томилогдох этгээд, цаашид тухайн байгууллагын зохион байгуулалтын нэгж дотроо ажлын байрны тодорхойлолт, эрхлэх асуудлын чиг үүрэгт нь өөрчлөлт орсны улмаас шилжүүлэн болон сэлгэн томилох, туршилтын хугацаагаар, Төрийн албаны тухай хуулийн хүрээнд тухайн албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр мэдүүлэг гаргах албан тушаалд томилогдохдоо хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээн авч, холбогдох баримт бичгийн хамт Авлигатай тэмцэх газарт нэн даруй хүргүүлнэ.

3.7. Мэдүүлгийг бүртгэж, хадгалах эрх бүхий албан тушаалтан авлигын эсрэг хууль тогтоомж, ашиг сонирхлын зөрчлийн талаар Авлигатай тэмцэх газарт мэдэгдэх үүрэгтэй.

3.8. Албан тушаалтан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан мэдэгдлийг дор дурдсан тохиолдолд гаргана:

3.8.1. ашиг сонирхлын зөрчилтэй буюу зөрчил үүсэж болзошгүй гэж үзвэл Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын түвшинд батлагдах шийдвэрийн төслийг боловсруулах болон шийдвэр гаргахад оролцох;

3.8.2. ашиг сонирхлын зөрчилтэй буюу зөрчил үүсэж болзошгүй гэж үзвэл Засгийн газар, Засгийн газрын гишүүн, яам, агентлаг, бүх шатны Засаг даргын түвшинд гарах шийдвэрийн төслийг боловсруулах болон шийдвэр гаргахад оролцох;

3.8.3. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах, шалгаруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах түвшинд гарах шийдвэр, гэрээ хэлцэлийн төсөл боловсруулах болон шийдвэр гаргахад оролцох.

3.9. Албан тушаалтан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ хувьцаат компанийн нийт хувьцааны 5 хүртэл хувийг эзэмшдэг бол ашиг сонирхлын зөрчилгүй гэж үзнэ.

Дөрөв. Хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогыг мэдүүлэх

4.1. Мэдүүлэгт дараах зүйлийг тусгана:

4.1.1. мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн байдал;

4.1.2. хувийн ашиг сонирхлын байдал;

4.1.3. хөрөнгө, орлого.

4.2. Энэ журмын 4.1.1-д заасан “Мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн байдал” гэсэн хэсэгт хамт амьдарч байгаа болон өрхийн бүртгэлд бүртгэлтэй, эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэд, эцэг, эхийг бичих бөгөөд Үүнд: гадаад улсад ажиллаж, сурч байгаа гэр бүлийн гишүүн хамаарна.

4.3. Энэ журмын 4.1.2-т заасан “Хувийн ашиг сонирхлын байдал” гэсэн хэсэгт дараах зүйлийг мэдүүлнэ:

4.3.1. “Мэдүүлэг гаргагчтай хамаарал бүхий этгээд” /Үүнд: Нийтийн албан

тушаалтны эрхлэх асуудлын хүрээ, шууд болон шууд бус нөлөөлөх боломжтой байгууллагад харьяалалтай болон хамааралтай ажил эрхэлж байгаа /байсан/ өрх тусгаарласан эцэг, эх, хүүхэд, төрсөн ах, эгч, дүү болон эхнэр /нөхөр/, хамтран амьдрагчийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүүгийн нэрийг түүний эцэг /эх/-ийн нэрийн хамт, ямар хамааралтай болох, ажиллаж байгаа /байсан/ байгууллага, албан тушаал, бизнес, үйл ажиллагааны чиглэл, төрсөн газар, үндсэн харьяаг тус тус мэдүүлнэ/;

4.3.2. “Мэдүүлэг гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд” /Үүнд: ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбогдсон хувь хүн, хуулийн этгээд, тэдгээртэй ямар харилцаа, хамааралтай /байсан/ болох, үйл ажиллагааны чиглэл, зорилго, байгууллага, ажил, албан тушаал эрхэлж байгаа /байсан/ болон тэдгээрийн төрөл зэргийг бичнэ/;

4.3.3. “Гишүүнчлэл, хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн гишүүн” /Үүнд: холбоо, нэгдэл, хөдөлгөөн, нутгийн зөвлөлийн тэргүүн, гишүүн, нам, улс төр, олон нийтийн байгууллагын гишүүнчлэлд байсан болон байгаа талаар бичнэ/;

4.3.4. “Төлөөлөл хэрэгжүүлсэн байдал” /Үүнд: хувь хүн, хуулийн этгээдийг төлөөлөн тодорхой үйл ажиллагаа, харилцаанд оролцсон талаар бичнэ/;

4.3.5. “Бэлэг, үйлчилгээ, өв залгамжлал, хандив, туслалцаа, хөнгөлөлт” /Үүнд: тухайн албан тушаалтны нэг сарын цалингаас дээш хэмжээний бэлэг, үйлчилгээ, хандив, туслалцаа, хөнгөлөлтийг мэдүүлнэ/;

Тайлбар: Энэ журамд заасан “байсан” гэдэг хугацаанд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу сүүлийн хоёр жилийн хугацааг хамааруулж ойлгоно.

4.3.6. “Урьдчилсан мэдүүлэг, бусад мэдэгдэл, тайлбар гаргасан байдал” /Үүнд: тухайн жилд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшихдээ гаргасан урьдчилсан мэдүүлэг, бусад мэдэгдэл, тайлбар гаргасан тухай бичнэ/;

4.3.7. Мэдүүлэг гаргагч албан тушаалын бүрэн эрхийнхээ дагуу олж авсан мэдээллийг хууль бусаар задруулах, албан үүрэгтээ хамааралгүй байдлаар ашиглахгүйг мэдэгдэж гарын үсэг зурж баталгаажуулна.

4.4. Хөрөнгө, орлогыг дараах байдлаар мэдүүлнэ:

4.4.1. Орлого хэсэгт:

–“үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”;

–“шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого” /Үүнд: албан байгууллага болон бусад хуулийн этгээд, хувь хүнээс олгосон шагнал, урамшуулал хамаарна/;

–“үйл ажиллагааны орлого” /Үүнд: үндсэн ажлаас гадуур ажиллаж олсон орлого, хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсний орлого хамаарна/;

–“хөрөнгийн орлого” /Үүнд: түрээс, эрхийн шимтгэл, ногдол ашиг, хүүгийн орлого, хөрөнгө бусдад ашиглуулсны орлого хамаарна/;

–“хөрөнгө борлуулсны орлого” /Үүнд: хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, хувьцаа борлуулсны орлого хамаарна/;

–“хандивын орлого” /Үүнд: бусдаас авсан мөнгөн хандив, тусламж хамаарна/;

–бусад орлого /Үүнд: шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, бүтээгдэхүүний ашигтай загвар зохион бүтээх, спорт, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого, шагнал, төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого, төрөөс олгож байгаа бүх төрлийн мөнгөн тэтгэмжийн орлого хамаарна/.

4.4.2. Хөрөнгө, зээл хэсэгт:

–“Орон сууц, барилга, байгууламж” /Үүнд: хувийн болон нийтийн орон сууц, үйлдвэр-лэл, үйлчилгээний зориулалттай барилга, авто зогсоол, гараж, зуслангийн байр, гэр зэргийг мэдүүлнэ. “Хийц, талбай” баганад тухайн барилга байгууламжийн хийц, өрөөний тоо, талбайн хэмжээг, зах зээлийн үнэлгээг мэдүүлэг гаргах үеийн зах зээлийн ханшаар үнэлж бичнэ. Гадаад улс орон, чөлөөт бүсэд байгаа орон сууц, барилга, байгууламжийг мэдүүлнэ/;

–“Тээврийн хэрэгсэл” /Үүнд: автомашин, өөрөө явагч хэрэгсэл, усан онгоц, нисэх

онгоц, бусад техник, тоног төхөөрөмжийг мэдүүлнэ. Зах зээлийн үнэлгээг мэдүүлэг гаргах үеийн зах зээлийн ханшаар үнэлж бичнэ/;

-“Мал, аж ахуй” /Үүнд: таван хошуу малаас гадна туслах аж ахуйн чиглэлээр үржүүлж байгаа гахай, тахиа, бусад тэжээвэр амьтдыг мэдүүлнэ/;

-“Газар” /Үүнд: мэдүүлэг гаргагчийн болон түүний гэр бүлийн гишүүдийн өмчлөл, эзэмшлийн болон ашиглаж байгаа газрыг мэдүүлнэ/;

-“Үнэт эдлэл, урлаг, түүхийн үнэт зүйл” /Үүнд: хөрөнгийн нэр, үнэлгээ, эзэмшигчийн нэр, эх үүсвэрийн тайлбарыг мэдүүлнэ/;

-“Хадгаламж, бэлэн мөнгө, хувийн харилцах болон төлбөрийн данс, картны данс- ны үлдэгдэл” /Үүнд: гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагад байгаа бүх төрлийн данс, картны үлдэгдлийг мэдүүлнэ. Гадаад валютыг тухайн жилийн эцсийн Монголбанкны ханшаар төгрөгт хөрвүүлэн дүнг бичнэ/;

-“Авлага” /Үүнд: хувь хүн, хуулийн этгээдээс авах бэлэн мөнгө, хөрөнгийн дүн, хугацаа, хүү, тайлбарыг тодорхой бичнэ/;

-“Зээл” /Үүнд: өөрийн болон гэр бүлийн гишүүдийн зээлийн талаарх мэдээллийг мэдүүлэх бөгөөд бусдаас зээлсэн бэлэн мөнгө, хөрөнгийн дүн, хугацаа, зээл, зээлийн хүүгийн дүн, зориулалтыг бичнэ/;

-“Компани, нөхөрлөл, хоршоонд оруулсан хөрөнгө оруулалт” /Үүнд: өөрийн болон гэр бүлийн гишүүдийн үүсгэн байгуулсан болон хувь нийлүүлсэн хуулийн этгээд, түүний толгой, охин, хараат болон салбар компани, аж ахуйн нэгж, гадаад, дотоодын хөрөнгийн биржээс худалдан авсан хувьцаа, бонд, бусад үнэт цаасыг мэдүүлнэ. Хөрөнгийн эх үүсвэрийг тодорхой бичнэ/;

-“Эрх, патент, тусгай зөвшөөрөл” /Үүнд: өөрийн болон гэр бүлийн гишүүдийн өмчлөл, эзэмшилд байгаа зохиогчийн эрх, патент, тусгай зөвшөөрлийг мэдүүлнэ/.

4.5. Мэдүүлэг гаргагч мэдүүлгийг засваргүй, товч тодорхой бичих бөгөөд асуулт болгонд хариулж, байхгүй орлого, хөрөнгө, зээлийг /-/ гэсэн тэмдэглэгээ хийнэ.

4.6. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэгт төрийн албан хаагчийн анкет, ажлын байрны тодорхойлолт, бусад шаардлагатай баримт бичгийг хавсаргана.

Тав. Хариуцлага

5.1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

АЛБАН ТУШААЛТНЫ ... ОНЫ ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ БОЛОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ

Нэг. Мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн байдал:

1.1. Мэдүүлэг гаргагч												
Ургийн овог:	Эцэг/эхийн нэр:				Нэр:							
Регистрийн дугаар:	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>
Иргэний үнэмлэхийн дугаар:												
Оршин суугаа газрын хаяг:					Гар утас: Ажлын утас: Гэрийн утас:				Цахим шуудангийн хаяг:			
Боловсрол, мэргэжил:	Байгууллагын нэр:											
Төрсөн газар:	Газар, хэлтэс, тасаг, алба:											
Үндсэн харьяа:	Албан тушаал:											
Сүүлийн хоёр жил ажилласан байгууллага, албан тушаал:												
Мэдүүлэг гаргах үндэслэл:	✓ тэмдэглэгээ хийнэ. Шинээр томилогдсон, Сонгогдсон <input type="checkbox"/> Шинэчлэн гаргасан <input type="checkbox"/> Их хэмжээний өөрчлөлт <input type="checkbox"/>											
Тухайн албан тушаалд томилогдсон, сонгогдсон огноо: он сар ...өдөр												

1.2. Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал					
Гэр бүлийн байдал	Эцэг /эх/-ийн нэр, нэр	Регистрийн дугаар	Төрсөн газар, үндсэн харьяа	Эрхэлж байгаа ажил, албан тушаал	Ажиллаж байгаа байгууллага, сурч байгаа сургууль, оршин суугаа газрын хаяг
Эхнэр, нөхөр, хамтран амьдрагч					

Хүүхэд							
Эцэг							
Эх							

Тайлбар: Хамт амьдарч байгаа болон өрхийн бүртгэлд бүртгэлтэй эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэд, эцэг, эхийг бичнэ.

Хоёр. Хувийн ашиг сонирхол

2.1. Мэдүүлэг гаргагчтай хамаарал бүхий этгээд

Эцэг /эх/-ийн нэр	Ямар хамааралтай болох	Ажиллаж байгаа /байсан/ байгууллага, албан тушаал	Бизнес, үйл ажиллагааны чиглэл	Төрсөн газар, үндсэн харьяа

Тайлбар: Нийтийн албан тушаалтны эрхлэх асуудлын хүрээ, шууд болон шууд бус нөлөөлөх боломжтой байгууллагад харьяалалтай болон хамааралтай ажил эрхэлж байгаа /байсан/ өрх тусгаарласан эцэг, эх, хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, эхнэр /нөхөр/, хамтран амьдрагчийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүүг бичнэ.

2.2. Мэдүүлэг гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд

Ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбогдсон хувь хүн, хуулийн этгээдийн нэр	Ямар харилцаатай /байсан/ болох /хуулийн этгээд бол ямар хамааралтай болох/	Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Байгууллага, ажил, албан тушаал /Эрхэлж байгаа /байсан/ үйл ажиллагааны төрөл/	Тайлбар

Тайлбар: Нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийн талаар бичнэ.

2.3. Гишүүнчлэл, хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн гишүүн

№	Хаана, ямар байгууллагад харьяалалтай болох	Албан тушаал, үүсгэн байгуулагч, гишүүн, дэмжигчийн аль нь болох	Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Тайлбар

Тайлбар: Холбоо, нэгдэл, хөдөлгөөн, нутгийн зөвлөлийн тэргүүн, гишүүн, нам, улс төр, олон нийтийн байгууллагын гишүүнчлэлд байсан болон байгаа талаар бичнэ.

2.4. Төлөөлөл хэрэгжүүлсэн байдал

№	Хувь хүн, хуулийн этгээдийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Төлөөллийг хаана, хэзээ, хэрхэн хэрэгжүүлсэн	Тайлбар

Тайлбар: Хувь хүн, хуулийн этгээдийг төлөөлөн тодорхой үйл ажиллагаа, харилцаанд оролцсон талаар бичнэ.

2.5. Бэлэг, үйлчилгээ, өв залгамжлал, хандив, тусалцаа, хөнгөлөлт

№	Эх сурвалжийн нэр, хаяг	Бэлэг, үйлчилгээ, өв залгамжлалын төрөл	Хандив, тусалцаа, хөнгөлөлтийн зориулалт	Үнэлгээ /төгрөг/	Тайлбар
	НИЙТ ДҮН				

Тайлбар: Тухайн албан тушаалтны нэг сарын цалингаас дээш хэмжээний бэлэг, үйлчилгээ авсныг бичнэ. Хууль ёсны өв залгамжлалаар хүлээн авсан буюу авах хөрөнгийн талаар мэдүүлнэ.

2.6. Урьдчилсан мэдүүлэг, бусад мэдэгдэл, тайлбар гаргасан байдал

№	Мэдүүлэг, мэдэгдлийн нэр	Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг хэзээ, хаана, хэнд гаргасан /Байгууллага, албан тушаалтан/	Гаргах болсон шалтгаан, нөхцөл	Товч утга

Тайлбар: Тухайн жилд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшихдээ гаргасан урьдчилсан мэдүүлэг, бусад мэдэгдэл, тайлбар гаргасан тухай бичнэ.

2.7. Албан тушаалын бүрэн эрхийнхээ дагуу олж авсан мэдээллийг хууль бусаар задруулах, албан үүрэгтээ хамааралгүй байдлаар ашиглахгүйг мэдэгдье.

Гарын үсэг:

Гурав. Хөрөнгө, орлого:

3.1. Орлого			/Төгрөгөөр/	
№	Орлогын төрөл	Орлогын дүн		Орлогын эх үүсвэр
		өөрийн	гэр бүлийн гишүүний	
1	Үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого			
2	Шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого /албан байгууллага болон бусад хуулийн этгээд, хувь хүнээс олгосон шагнал, урамшуулал/			
3	Үйл ажиллагааны орлого /үндсэн ажлаас гадуур ажиллаж олсон орлого, хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсний орлого/			
4	Хөрөнгийн орлого /түрээс, эрхийн шимтгэл, ногдол ашиг, хүүгийн орлого, хөрөнгө бусдад ашиглуулсны орлого/			
5	Хөрөнгө борлуулсны орлого /Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, хувьцаа борлуулсны орлого/			
6	Хандивын орлого /бусдаас авсан мөнгөн хандив, тусламж/			
7	Бусад орлого /шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, бүтээгдэхүүний ашигтай загвар зохион бүтээх, спорт, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого, шагнал, телбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого, төрөөс олгож байгаа бүх төрлийн мөнгөн тэтгэмжийн орлого/			
	Нийт дүн			

Тайлбар: Тайлант хугацаанд олсон орлогыг бичнэ.

3.2. Хөрөнгө, зээл

я Орон сууц, барилга, байгууламж байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх

3.2.1. Орон сууц, барилга, байгууламж						
№	Орон сууц, барилга, байгууламжийн төрөл	Хийц, талбай	Байршил /хаяг/	Зах зээлийн үнэлгээ /төгрөг/	Бүртгэлийн гэрчилгээний дугаар	Эх үүсвэрийн тайлбар

Нийт дүн	
-----------------	--

6. **“Хүлээлгэн өгсөн хүний гарын үсэг”** баганад мэдүүлгийг хүлээлгэн өгсөн албан тушаалтнаар гарын үсэг зуруулж баталгаажуулна.
7. **“Хүлээн авсан албан тушаалтны гарын үсэг”** баганад мэдүүлгийг хүлээн авсан эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.
8. **“Тайлбар”** баганад их хэмжээний өөрчлөлтийг мэдүүлж байгаа бол “их хэмжээний өөрчлөлт” гэж бичих бөгөөд зааврын 4-т бичигдсэн бусад байдлаар гэдгийг тодруулна. Мөн бусад шаардлагатай тайлбарыг бичнэ.

ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН УРЬДЧИЛСАН МЭДҮҮЛГИЙН БҮРТГЭЛИЙН МАЯГТЫН НӨХӨХ ЗААВАР

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг”-ийг бүртгэхэд энэхүү зааврыг мөрдөнө.

“Овог, нэр” баганад урьдчилсан мэдүүлэг гаргагчийн овог, нэрийг тодорхой бичнэ. **“Нэр дэвших албан тушаал”** баганад нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн нэр дэвшиж байгаа албан тушаалыг тодорхой бичнэ.

“Мэдүүлгийг хүлээн авсан он, сар, өдөр” баганад тухайн урьдчилсан мэдүүлгийг хүлээн авсан он, сар, өдрийг бичнэ.

“Мэдүүлгийг хянуулахаар хүргүүлсэн он, сар, өдөр” баганад тухайн урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн он, сар, өдөр болон албан бичгийн дугаарыг бичнэ.

“Ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх” баганад тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэх талаар Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн хариуны товч утгыг бичнэ. Үүнд: ашиг сонирхлын зөрчил үүсэх бол “тийм”, үүсэхгүй бол “үгүй” гэж бичнэ.

“Нэр дэвшсэн этгээдийг томилсон шийдвэрийн дугаар, огноо” баганад нэр дэвшсэн этгээдийг нийтийн албанд томилсон бол шийдвэрийн дугаар, он, сар, өдрийг бичнэ.

“Нэр дэвшигчээс бичгээр танилцуулсан эсэх” баганад “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 19.1-д “Албан тушаалтан нийтийн албанд орох үед хуулиар зөвшөөрөөгүй өөр ажил, үүрэг, гэрээ гүйцэтгэж, эрх эдэлж байгаа бол энэ тухай дээд шатны албан тушаалтанд бичгээр танилцуулах үүрэгтэй” гэж заасны дагуу нэр дэвшигч этгээд бичгээр танилцуулга гаргасан эсэх талаар бичнэ. Хэрэв бичгээр танилцуулсан бол “тийм”, танилцуулаагүй бол “үгүй” гэж бичнэ.

“Танилцуулга хүлээн авсан дээд албан тушаалтны шийдвэр” баганад “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-д “энэ хуулийн 19.1-д заасан танилцуулга хүлээн авсан албан тушаалтан ажлын байрны шаардлагыг харгалзан 30 хоногийн дотор давхар эрхэлж болохгүй алба, ажил, үүргээс чөлөөлөгдөх, гэрээ болон эрхийг цуцлах эсэх тухай шийдвэр гаргаж холбогдох албан тушаалтанд бичгээр мэдэгдэнэ” гэж заасны дагуу танилцуулгыг хүлээн авсан албан тушаалтны гаргасан шийдвэрийг бичнэ. Хэрэв давхар эрхэлж байгаа ажил, алба, үүргээс чөлөөлөгдөх, гэрээ болон эрхийг цуцлах тухай шийдвэр гаргасан бол “цуцалсан”, цуцлаагүй бол “цуцлаагүй” гэж бичнэ.

МЭДЭГДЭЛ, ТАЙЛБАР, МЭДЭЭЛЭЛ, ТЭДГЭЭРИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БҮРТГЭЛИЙН МАЯГТЫГ НӨХӨХ ЗААВАР

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг бүртгэхэд энэхүү зааврыг мөрдөнө.

“Овог, нэр” баганад урьдчилсан мэдүүлэг гаргагчийн овог, нэрийг тодорхой бичнэ. **“Нэр дэвших албан тушаал”** баганад нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн нэр дэвшиж байгаа албан тушаалыг тодорхой бичнэ.

“Мэдүүлгийг хүлээн авсан он, сар, өдөр” баганад тухайн урьдчилсан мэдүүлгийг хүлээн авсан он, сар, өдрийг бичнэ.

“Мэдүүлгийг хянуулахаар хүргүүлсэн он, сар, өдөр” баганад тухайн урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн он, сар, өдөр болон албан бичгийн дугаарыг бичнэ.

“Ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх” баганад тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэх талаар Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн хариуны товч утгыг бичнэ. Үүнд: ашиг сонирхлын зөрчил үүсэх бол “тийм”, үүсэхгүй бол “үгүй” гэж бичнэ.

“Нэр дэвшсэн этгээдийг томилсон шийдвэрийн дугаар, огноо” баганад нэр дэвшсэн этгээдийг нийтийн албанд томилсон бол шийдвэрийн дугаар, он, сар, өдрийг бичнэ.

“Нэр дэвшигчээс бичгээр танилцуулсан эсэх” баганад “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 19.1-д “Албан тушаалтан нийтийн албанд орох үед хуулиар зөвшөөрөөгүй өөр ажил, үүрэг, гэрээ гүйцэтгэж, эрх эдэлж байгаа бол энэ тухай дээд шатны албан тушаалтанд бичгээр танилцуулах үүрэгтэй” гэж заасны дагуу нэр дэвшигч этгээд бичгээр танилцуулга гаргасан эсэх талаар бичнэ. Хэрэв бичгээр танилцуулсан бол “тийм”, танилцуулаагүй бол “үгүй” гэж бичнэ.

“Танилцуулга хүлээн авсан дээд албан тушаалтны шийдвэр” баганад “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-д “энэ хуулийн 19.1-д заасан танилцуулга хүлээн авсан албан тушаалтан ажлын байрны шаардлагыг харгалзан 30 хоногийн дотор давхар эрхэлж болохгүй алба, ажил, үүргээс чөлөөлөгдөх, гэрээ болон эрхийг цуцлах эсэх тухай шийдвэр гаргаж холбогдох албан тушаалтанд бичгээр мэдэгдэнэ” гэж заасны дагуу танилцуулгыг хүлээн авсан албан тушаалтны гаргасан шийдвэрийг бичнэ. Хэрэв давхар эрхэлж байгаа ажил, алба, үүргээс чөлөөлөгдөх, гэрээ болон эрхийг цуцлах тухай шийдвэр гаргасан бол “цуцалсан”, цуцлаагүй бол “цуцлаагүй” гэж бичнэ.

Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээдээс оффшор бүсэд өөрийн нэр дээр банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан өмчийн байдалд орсон өөрчлөлт, орлогын талаарх урьдчилсан мэдүүлгийн бүртгэлийн маягтыг нөхөх заавар

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 101 дүгээр зүйлд зааснаар Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээдээс оффшор бүсэд өөрийн нэр дээр банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан өмчийн байдалд орсон өөрчлөлт, орлогын талаарх Авлигатай тэмцэх газарт бичгээр мэдэгдсэн болон мэдүүлсэн тохиолдолд дараах зааврын дагуу бүртгэнэ. Үүнд:

“Мэдүүлэг гаргагч” баганын “байгууллага, албан тушаал” дэд баганад мэдүүлэг гаргагчийн харьяа байгууллага, эрхэлж байгаа албан тушаалын нэрийг бичнэ.

“Мэдүүлэг гаргагч” баганын “овог, нэр” дэд баганад мэдүүлэг гаргагчийн овог, нэрийг бичнэ.

“Мэдүүлэг гаргагч” баганын “регистрийн дугаар” дэд баганад мэдүүлэг гаргагчийн регистрийн дугаарыг бичнэ.

“Мэдүүлэг гаргагчийн хамаарал бүхий этгээд” баганын “овог, нэр” дэд баганад мэдүүлэг гаргагчийн хамаарал бүхий этгээдийн овог, нэрийг бичнэ.

“Мэдүүлэг гаргагчийн хамаарал бүхий этгээд” баганын “регистрийн дугаар” дэд баганад мэдүүлэг гаргагчийн хамаарал бүхий этгээдийн регистрийн дугаарыг бичнэ.

“Мэдүүлэг гаргагчийн хамаарал бүхий этгээд” баганын “ямар хамааралтай болох” дэд баганад Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д зааснаар “тухайн нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээд”-ийн аль нь болохыг бичнэ.

“Оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэр” баганад Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.3-т зааснаар Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 326 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрийн жагсаалт”-д заагдсан 49 нутаг дэвсгэрээс хамаарахыг нь бичнэ.

“Оффшор бүсэд” баганын “өөрийн нэр дээр банкны данс нээлгэсэн”, “мөнгөн хөрөнгө байршуулсан”, “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн”, “хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан” зэрэг дэд баганын тохирох хэсэгт тус тус (+) тэмдэглэгээ хийнэ.

“Оффшор бүсэд мөнгөн хөрөнгө байршуулсан, данс нээлгэсэн, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, зорилго” баганын “суралцах”, “хөдөлмөр эрхлэх”, “эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах” зэрэг дэд баганын тохирох хэсэгт тус тус (+) тэмдэглэгээ хийнэ.

“Өмчийн байдалд орсон өөрчлөлт, орлого” баганын «Нээлгэсэн банкны дансаа хаалгасан»; «Банканд байршуулсан мөнгөн хөрөнгөө татсан»; «Хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрх»-ийг “худалдсан”, “шилжүүлсэн”, “татсан” зэрэг; «Хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол» “үйл ажиллагаагаа зогсоосон”, “эзэмших”, “ашиглах”, “захиран зарцуулах эрх”-ээ “худалдсан”, “шилжүүлсэн”, “дуусгавар болгосон”

зэрэг дэд баганын тохирох хэсэгт тус тус (+) тэмдэглэгээ хийнэ.

“Мэдэгдэл хүлээлгэн өгсөн” баганын “он, сар, өдөр” дэд баганад мэдэгдэл хүлээлгэн өгсөн мэдүүлэг гаргагч албан тушаалтнаас ирүүлсэн бичгийн он, сар, өдрийг бичнэ.

“Мэдэгдэл хүлээлгэн өгсөн” баганын “хэлбэр” дэд багананд “өөрийн биеэр”, “баталгаат шуудангаар”, “электрон шуудангаар”, “бусад” зэргийн тохирох хэсэгт тус тус (+) тэмдэглэгээ хийнэ.

“Мэдэгдэл хүлээлгэн өгсөн” баганын “Албан тушаалтны гарын үсэг” дэд багананд оффшорын талаар Авлигатай тэмцэх газарт биечлэн ирж, бичгээр мэдэгдсэн албан тушаалтнаар гарын үсэг зуруулна.

“Мэдэгдэл хүлээн авсан албан тушаалтны гарын үсэг” баганад бичгээр ирүүлсэн мэдэгдлийг хүлээн авсан Авлигатай тэмцэх газрын холбогдох албан тушаалтан гарын үсэг зурна.

“Тайлбар” багананд мэдүүлэг гаргагч, түүний хамаарал бүхий этгээд оффшорын талаар Авлигатай тэмцэх газарт бичгээр мэдэгдсэн эсхүл мэдүүлсэн аль нь болох талаар бичнэ.

АЛБАН ТУШААЛТНЫ МЭДҮҮЛЭГ, МЭДЭГДЭЛ, ТАЙЛБАРЫН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ӨГСӨН ТУХАЙ БҮРТГЭЛ

..... ОН

Аймаг, нийслэл.....
Сум, дүүрэг.....
Байгууллагын нэр.....

№	Хүсэлт гаргагчийн овог, нэр	Хүсэлт Хүсэлт гаргасан огноо	Авах мэдээллийн төрөл: (+) тэмдэглэгээ				Зөвшөөрөл олгосон албан тушаалтны нэр	Мэдээлэл өгсөн огноо	Мэдээлэл авсан хүний гарын үсэг	Мэдээлэл өгсөн албан тушаалтны гарын үсэг
			хөрөнө орлогын мэдүүлэг	хувийн ашиг сонирхлын мэдүүлэг	ашиг сонирхлын зөрчлийг гэдгээ илэрхийлсэн мэдээлэл	ашиг сонирхлын зөрчлэлтэй гаж ойлгогдохуйц нөхцөл байдал үүссэн нөхцөлд бичгээр гаргасан тайлбар				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

АЛБАН ТУШААЛТНЫ МЭДҮҮЛЭГ, МЭДЭГДЭЛ, ТАЙЛБАРЫН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ӨГСӨН ТУХАЙ БҮРТГЭЛИЙН МАЯГТЫГ НӨХӨХ ЗААВАР

“Хүсэлт гаргагчийн овог, нэр” баганад албан тушаалтны мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын талаар албан ёсоор хүсэлт гаргасан иргэн, эсхүл эрх бүхий байгууллагын холбогдох албан тушаалтны овог, нэрийг бичнэ.

“Хүсэлт гаргасан огноо” баганад мэдээлэл авах хүсэлтийг холбогдох байгууллагад гаргасан он, сар, өдрийн бичнэ.

“Авах мэдээллийн төрөл” баганын “хөрөнгө орлогын мэдүүлэг”, “хувийн ашиг сонирхлын мэдүүлэг”, “ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл”, “ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүссэн нөхцөлд бичгээр гаргасан тайлбар” зэрэг дэд багананын тохирох хэсэгт тус тус (+) тэмдэглэгээ хийнэ.

“Зөвшөөрөл олгосон албан тушаалтны нэр” баганад мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэж, хадгалж буй байгууллагын мэдээлэл өгөх зөвшөөрөх олгосон удирдах албан тушаалтны нэрийг бичнэ.

“Мэдээлэл өгсөн огноо” баганад хүсэлтийн дагуу мэдээлэл өгсөн хугацааг дэлгэрэнгүй бичнэ. Жишээлбэл: 2019.03.31

“Мэдээлэл авсан хүний гарын үсэг” баганад мэдээллийг хүлээн авсан иргэн гарын үсэг зурна.

“Мэдээлэл өгсөн албан тушаалтны гарын үсэг” баганад мэдээллийг хүлээлгэн өгсөн тухайн мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэж, хадгалж буй байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурна.



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018.11.21

Дугаар А/121

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын “Гурав” дахь хэсгийн 3.5, Захиргааны ерөнхий хуулийн 59, 60 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журам” / шинэчлсэн найруулга/-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг нийтийн албаны удирдлагад, журмыг хэрэгжүүлэх талаар мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс /Эрхэлсэн комиссар Х.Хашбаатар/-т даалгасугай.

3. Журмыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтэс (Эрхэлсэн комиссар З.Баасанням)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан тус газрын даргын 2012 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн “Журам батлах тухай” 196 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Журмыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР

Х.ЭНХЖАРГАЛ

АЛБАН ТУШААЛТНЫ ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ БОЛОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙГ БҮРТГЭХ, ХЯНАХ, ХАДГАЛАХ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ /шинэчилсэн найруулга/

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмаар Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх хэсэг, Монгол Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай” 5 дугаар тогтоолын “Хоёр” дахь хэсгийн 2.1 дэх хэсэг, 2014 оны 20 дугаар тогтоолоор баталсан “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах зарим албан тушаалтны жагсаалт”-д заасан этгээд *цаашид “нийтийн албан тушаалтан” гэх/-эс* гаргасан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг *цаашид “мэдүүлэг” гэх/*, баталгааны маягт, нийтийн албанд нэр дэвшигчээс гаргасан хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг *цаашид “урьдчилсан мэдүүлэг” гэх/*, нийтийн албан тушаалтан албан тушаалтнаас албан үүргээ гүйцэтгэхэд сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж гаргасан мэдэгдэл *цаашид “мэдэгдэл” гэх/*, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүссэн тохиолдолд гаргасан тайлбар *цаашид “тайлбар” гэх/-*ыг тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан *цаашид “эрх бүхий албан тушаалтан” гэх/-*аас бүртгэх, хянах, тайлагнах, хадгалахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулна.

1.2 Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар бичих талаар байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан захидал, хүсэлт, асуулт, тэдгээрт өгсөн хариулт зөвлөгөө хувь хүний нууцад хамаарах бөгөөд эрх бүхий албан тушаалтан албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдуулан илэрхий болсон хувь хүний нууцыг чанд хадгалж, албан үүргийг гүйцэтгэж байхдаа болон албан тушаалаас чөлөөлөгдсөнөөс хойш ямар нэг зорилгоор ашиглахыг хориглоно.

Хоёр. Эрх бүхий албан тушаалтны эрх, үүрэг

1.1 Эрх бүхий албан тушаалтан Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.3, Монгол Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай” 05 дугаар тогтоолын “Гурав” дахь хэсэгт зааснаас гадна дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

1.1.1 Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах төлөвлөгөө боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, гүйцэтгэлийг тооцох;

1.1.2 Байгууллага, салбарын хэмжээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх хууль тогтоомжийг сурталчлах, сургалт зохион байгуулах, нийтийн албан тушаалтнуудад мэдүүлэг, урьдчилсан мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар гаргах талаар арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгөх;

1.1.3 Байгууллагын удирдлагын шийдвэрээр мэдүүлгийн цахим системд нэвтрэх, цахим системийн нууцлал, аюулгүй байдлыг хангах;

1.1.4 Мэдүүлэг гаргагч хуульд заасан үндэслэлээр мэдүүлэг болон урьдчилсан мэдүүлэг мэдүүлэх тохиолдолд мэдүүлгийн цахим системд нэн даруй эрхийг үүсгэн, энэ талаар мэдүүлэг гаргагчид мэдэгдэх, хяналт тавих;

1.1.5 Нийтийн албан тушаалтнаас мэдүүлэг, урьдчилсан мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар, баталгааны маягт, холбогдох бусад баримтыг хуулийн хугацаанд, үнэн зөв гаргаж өгөхийг шаардах;

1.1.6 Албан тушаалтнаас гаргасан мэдүүлэг, урьдчилсан мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар, баталгааны маягтад холбогдох мэдээллийг бүрэн гүйцэд тусгасан болон хуулийн хугацаанд мэдүүлсэн эсэхэд хяналт тавих;

1.1.7 Мэдүүлэг гаргагчийн нэрсийн жагсаалт, мэдүүлгийн тайланг хугацаанд нь үнэн зөв гаргаж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх;

1.1.8 Байгууллагын удирдлагын зөвшөөрлөөр албан тушаалтны мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын талаар мэдээлэл өгөх журмын дагуу бүртгэлийг зохих журмын дагуу хөтлөх, тайланг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх;

1.1.9 Харьяа салбар, нэгжийн эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, заавар зөвлөгөө өгөх, тайлан мэдээний үнэн бодит байдлыг хариуцах;

1.2 Мэдүүлгийг бүртгэх, тайлагнах хүрээнд:

1.2.1 Мэдүүлэг гаргагчаас гаргасан мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын болон энэ талаар мэдээлэл өгсөн тухай бүртгэлийг баталсан маягт, зааврын дагуу хөтлөх, биелэлтийг хангах;

1.2.2 Салбар, нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан мэдүүлгийг хуульд заасан хугацаанд хүлээн авч дууссанаас хойш тайлан, мэдээг 7 хоногийн дотор дээд шатны байгууллагад хүргүүлэх;

1.2.3 Дээд шатны байгууллага нь харьяа салбар, нэгж, байгууллагуудаас ирүүлсэн тайланг нэгтгэж, Авлигатай тэмцэх газарт жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор хүргүүлэх;

1.3 Мэдүүлэг, тайлбар, мэдэгдэл, тайлан мэдээг хадгалах хүрээнд:

1.3.1 Албан тушаалтнаас тухайн байгууллагад ажилласан сүүлийн 3 жилийн хугацаанд гаргасан мэдүүлэг, баталгааны маягт, мэдэгдэл, тайлбар, тайлан мэдээг хадгалах;

1.3.2 Энэ хэсгийн 2.3.1-д заасан баримт, материал нь байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад тусгагдсан байх бөгөөд тухайн байгууллагад ажилласан сүүлийн 3 жилээс өмнөх хугацааны баримтуудыг архивын нэгж болгон эмхэлж, байгууллагын архивт хүлээлгэн өгөх;

1.3.3 Мэдүүлэг, урьдчилсан мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар, холбогдох бусад тайлан, мэдээний эмх цэгц, шуурхай байдлыг хангах, хэрэгцээтэй баримтыг эрж хайх болон ашиглуулах нөхцөлийг хялбарчлах, зөв бүрдүүлэх зорилгоор байгууллагын салбар, нэгж, албан тушаалтан тус бүрээр цагаан толгойн үсгийн дарааллаар товёоглон гал, усны аюул, тоос шороо, гадны бусад нөлөөнөөс найдвартай хамгаалагдсан зориулалтын сейф, төмөр шүүгээ бүхий ажлын байранд хадгалах;

1.3.4 Авлигатай тэмцэх газар эсхүл өөрийн байгууллагын удирдах албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар болон тайлан мэдээ, холбогдох бусад баримтыг хадгалж байгаа газраас гадагш гаргах, бусдад дамжуулах, шилжүүлэх, үзүүлэх, ил задгай байлгахыг хориглоно.

1.3.5 Архивт хүлээлгэн өгсөн мэдүүлэг, холбогдох баримт бичигтэй танилцах, ашиглах үйл ажиллагааг “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар иргэдэд мэдээлэл өгөх журам”-ын дагуу тухайн байгууллагын

архивын ажилтан хэрэгжүүлнэ.

Гурав. Нийтийн албаны удирдлагын эрх, үүрэг

3.1 Нийтийн албаны удирдлага Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, хувийн ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хууль, холбогдох хууль тогтоомжид заасан нийтлэг эрх үүргээс гадна дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1 Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах;

3.1.2 Байгууллага, өөрийн харьяа салбар, нэгжийн эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих;

3.1.3 Байгууллагын захиргаа, хуулийн асуудал эрхэлсэн албан тушаал /ажлын байр/-ын тодорхойлолтод Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль, тогтоомжид заасан эрх бүхий албан тушаалтны чиг үүргийг тусган баталгаажуулах;

3.1.4 Эрх бүхий албан тушаалтнаар нийтийн албанд ажилласан мэдлэг, ур чадвар, дадлага туршлагатай албан тушаалтныг томилох, түүнийг тогтвор суурьшилтай ажиллуулах, жил бүрийн төсөвт цалингийн нэмэгдлийг тусган баталгаажуулж байх;

3.1.5 Эрх бүхий албан тушаалтныг чөлөөлөх, шинээр томилох болон түр хугацаагаар чөлөөлөгдсөн тухай бүрт Авлигатай тэмцэх газарт бичгээр мэдэгдэж, чиг үүргийг тасралтгүй хэвийн явагдах нөхцөлийг бүрдүүлэх, хяналт тавих;

3.1.6 Харьяа салбар, нэгж байгууллагын эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;

3.1.7 Эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавьж, чадавхижуулах, тэдгээрээс эрх, үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах бүхий л нөхцөлөөр хангах, дэмжин туслах, шаардлагатай мэдээллээр хангах;

3.1.8 Авлигатай тэмцэх газраас гаргасан хууль ёсны шийдвэрийг биелүүлэх, шаардлагатай баримт, мэдээ, мэдээллийг саадгүй гаргаж өгөх;

3.1.9 Хууль тогтоомжид заасан бусад.

Дөрөв. Бусад

4.1 Мэдүүлэг гаргагчийн мэдүүлэг, урьдчилсан мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг иргэд, олон нийтэд нээлттэй байлгах, танилцах боломжоор хангах үүргийг байгууллагын удирдлага, эрх бүхий албан тушаалтан хариуцах бөгөөд мэдээлэл өгөхтэй холбогдсон харилцааг тусгай журмаар зохицуулна.

4.2 Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомж, энэхүү журмыг зөрчсөн байгууллагын удирдлага болон эрх бүхий албан тушаалтанд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
~~2018~~ оны ~~11~~ сарын ~~17~~-ны
өдрийн ~~4035~~ дугаарт бүртгээ.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018.11.14

Дугаар А/122

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 59, 60 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар иргэдэд мэдээлэл өгөх журам” /шинэчилсэн найруулга/-ыг нэгдүгээр, “Мэдээлэл авах хүсэлт гаргах маягт”-ыг хоёрдугаар, “Албан тушаалтны ... оны хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт /хураангуй”-ыг гуравдугаар, “Албан тушаалтны ... оны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн маягт /хураангуй”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нийтийн албаны удирдлагуудад, журмыг хэрэгжүүлэх чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллахыг Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс /Эрхэлсэн комиссар Х.Хашбаатар/-т үүрэг болгосугай.

3. Журмыг баталснаас хойш ажлын 5 өдрийн дотор Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Тамгын хэлтэс /Эрхэлсэн комиссар З.Баасанням/-т даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан тус газрын даргын 2012 оны “Журам батлах тухай” 196 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар мэдээлэх, мэдээлэл өгөх журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Журмыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР

Х.ЭНХЖАРГАЛ

АЛБАН ТУШААЛТНЫ ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН БОЛОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙН ТАЛААР ИРГЭДЭД МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ ЖУРАМ /шинэчилсэн найруулга/

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг /цаашид “Мэдүүлэг” гэх/, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл /цаашид “мэдэгдэл” гэх/, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүссэн нөхцөлд бичгээр гаргасан тайлбар /цаашид “тайлбар” гэх/-ын талаар хүсэлт гаргасан иргэн, албан тушаалтан, байгууллагад мэдээлэл өгөх, Авлигатай тэмцэх газраас нийтийн албан тушаалтны хөрөнгө орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хураангуй хэлбэрээр мэдээлэхтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Энэ зүйлийн 1.1 дэх хэсэгт заасан мэдээлэл өгөхөд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, хувийн ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, энэ журмыг баримтална.

1.3 Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбартай холбоотой мэдээлэл нь хувь хүний нууцад, хүсэлтийн агуулга, мэдээлэл авсан иргэн, албан тушаалтан, байгууллагын талаарх мэдээлэл нь албаны нууцад хамаарна.

1.4 Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбартай холбоотой мэдээллийг түүнийг хадгалж байгаа байгууллагын удирдах албан тушаалтны бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн олгоно.

Хоёр. Мэдээлэх хэлбэр, хугацаа

2.1 Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хураангуй хэлбэрээр, батлагдсан маягтын дагуу жил бүрийн хоёрдугаар улиралд багтаан Авлигатай тэмцэх газрын цахим мэдээллийн сүлжээнд байршуулж, иргэд, олон нийтийг энэ тухай мэдээлэл авах боломжоор хангана.

2.2 Иргэн, албан тушаалтан, байгууллага хүсэлт гаргавал мэдүүлгийг зөвхөн батлагдсан маягтын дагуу хураангуй хэлбэрээр, мэдэгдэл, тайлбарыг эх хувиар нь тус тус танилцуулна.

2.3 Энэ журмын 4.1 дэх хэсэгт заасан байгууллага мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэж, хадгалж буй байгууллагад хандан албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаарх мэдээллийг ирүүлэх хүсэлт албан ёсоор ирүүлсэн тохиолдолд нэн даруй шийдвэрлэж, баталгаажуулан хариу өгнө. Шаардлагатай гэж үзвэл Авлигатай тэмцэх газар мэдүүлгийг цахим системээс эх хувиар нь хэвлэж, баталгаажуулж хүргүүлнэ.

Гурав. Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын талаар мэдээлэл өгөх

3.1 Иргэн нийтийн албан тушаалтны мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын талаар мэдээлэл авах хүсэлтийг тухайн албан тушаалтны мэдүүлгийг хадгалж буй байгууллагын удирдлагад энэ журмын хоёрдугаар хавсралтад заасан маягтын дагуу биечлэн эсхүл цахимаар гаргана.

3.2 Хүсэлтийг хүлээн авснаас хойш тухайн байгууллагын удирдлага ажлын 3 өдөрт

хянан үзэж, энэхүү журмаар тогтоосон хүрээнд мэдээлэл өгөх зөвшөөрлийг зөвхөн бичгээр олгоно.

3.3 Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын талаар мэдээлэл өгөх боломжгүй нөхцөл байдал тогтоогдвол энэ тухай үндэслэлээ хүсэлт гаргагчид тайлбарлах ба шаардлагатай гэж үзвэл албан ёсоор хариу өгнө.

3.4 Тухайн байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан /цаашид “ЭБАТ” гэх/ энэ журмын 3.2 дахь хэсэгт заасан зөвшөөрлийг үндэслэн мэдээлэл авахыг хүссэн иргэний овог, нэр, оршин суугаа хаягийг иргэний үнэмлэхтэй тулган, холбогдох утасны дугаар, холбогдох бусад мэдээллийг хянаж үзнэ.

3.5 Энэ журмын 3.4 дэх хэсэгт зааснаар мэдээллийг хянах явцад ямар нэг зөрчил илрээгүй бол Хувь хүний нууцын тухай хууль, энэ журмыг урьдчилан танилцуулсны дараа энэхүү журмын гурав, дөрөвдүгээр хавсралтад заасан маягтын дагуу мэдээллийг хэвлэмэл хэлбэрээр саадгүй гаргаж өгнө.

3.6 ЭБАТ мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын талаар мэдээлэл авах хүсэлт, мэдээлэл өгсөн тухай бүртгэлийг хөтөлж энэ тухай тайланг жил бүр Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ. Иргэний хүсэлтийг тухайн байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын нэгж болгон архивт шилжүүлнэ.

3.7 Энэ журмын 3.3 дахь хэсэгт заасан үндэслэлийг хүлээн зөвшөөрөхгүй тухайн иргэн Авлигатай тэмцэх газарт хандан мэдээлэл авах хүсэлт гаргаж болно.

3.8 Авлигатай тэмцэх газар хүсэлтийг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу хянан шийдвэрлэнэ.

Дөрөв. Бусад

4.1 Хуулиар тусгайлан эрх олгогдсон шүүх, прокурор, цагдаа, тагнуулын болон бусад эрх бүхий төрийн байгууллага зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу мэдүүлэгтэй танилцаж, мэдээлэл авч болно.

4.2 Энэ журмын 4.1 дэх хэсэгт заасан байгууллагаас Авлигатай тэмцэх газарт гаргасан албан ёсны хүсэлтийг үндэслэн мэдүүлгийн хуулбарыг өгч болох ба энэ тухай бүртгэл хөтөлнө.

4.3 Энэ журамд зааснаас бусад тохиолдолд мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын талаар мэдээлэх, мэдээлэл өгөх, зөвшөөрөл олгохыг хориглоно.

4.4 Энэ журмын 4.3-д заасныг зөрчсөн нь тогтоогдсон буруутай албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МЭДЭЭЛЭЛ АВАХ ХҮСЭЛТ ГАРГАХ МАЯГТ

/Цахим хаягаар дамжуулан авах бол иргэний үнэмлэхний хуулбарыг хавсаргана./

20 оны ... сарын ...

... .. ХОТ

НЭГ: ХҮСЭЛТ ГАРГАХ ИРГЭН ДАРААХ МЭДЭЭЛЛИЙГ БИЧНЭ.

.... нийслэл /Аймаг, сум, дүүрэг/-ийн /байгууллагын нэр/-ийн дарга танаа

1. Хүсэлт гаргаж байгаа иргэний мэдээлэл

1. Ургийн овог:	2. Эцгийн нэр:	3. Өөрийн нэр:
4. Төрсөн огноо:	5. Регистрийн дугаар:	
6. Хүйс: эрэгтэй/эмэгтэй		
7. Оршин суугаа хаяг:		
8. Холбоо барих утасны дугаар:		
9. Шуудангийн хайрцаг:	10. Цахим шуудангийн хаяг:	

2. Мэдээлэл авах зорилго, хэрэгцээ, шаардлага:

..... /тодорхой бичих/

3. Мэдээллийн төрөл: /аль нь болох ✓ гэж тэмдэглэх// гэж

- Хөрөнгө орлогын мэдүүлэг
- Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг
- Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл
- Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүссэн нөхцөлд бичгээр гаргасан тайлбар

ХОЁР: ЗӨВХӨН ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЛБАН ТУШААЛТАН БИЧНЭ.

1. Зөвшөөрөл олгосон:

Албан тушаалтны овог, нэр:	
Албан тушаал:	
Гарын үсэг:	
Огноо:	

2. Зөвшөөрөл олгохоос татгалзсан үндэслэл	
<input type="checkbox"/>	Хүсэлт тодорхой бус
<input type="checkbox"/>	Бусад: /дэлгэрэнгүй бичих/

ГУРАВ: ЗӨВХӨН МЭДЭЭЛЭЛ ӨГСӨН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН /ЭБАТ/ БИЧНЭ.

1. Мэдээлэл өгсөн хэлбэр	
Мэдээлэл хүлээн авсан иргэний овог, нэр	
Гарын үсэг:	
Огноо:	
Цахимаар илгээсэн бол	иргэний цахим хаяг
	илгээсэн огноо

2. Мэдээлэл өгсөн эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/	
Албан тушаалтны овог, нэр:	
Албан тушаал:	
Гарын үсэг:	
Огноо:	

АЛБАН ТУШААЛТНЫ ... ОНЫ ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙН ХУРААНГУЙ МЭДЭЭЛЭЛ

/Авлигатай тэмцэх газрын албан ёсны цахим сүлжээнд жил бүрийн хоёрдугаар улиралд багтаан байршуулна./

201... оны ... дүгээр сарын ...-ний өдөр

Улаанбаатар хот

№	Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, зээл																													
	Мэдүүлэг гаргагч	Орлого	Орон сууц, барилга, байгууламж										Тээврийн хэрэгсэл	Мал аж ахуй	Гаазар	Хадгаламж, бэлэн мөнгө, данс, картын үлдэгдэл	Авлагын нийт дүн /мян.төг/	Анх авсан зээлийн нийт хэмжээ /мян.төг/	Компани, нөхөрлөл, хоршоонд оруулсан хөрөнгө оруулалт	Эрх, патент, тусгай зөвшөөрлийн төрөл										
Орон сууц			Үйлдвэрлэл үйлчилгээний				Бусад				/Тоогоор/																			
1	Овог, нэр	Мэдүүлэг гаргагчийн нийт орлого	Аминь орон сууц	Нийтийн орон сууц	Зуслангийн байшин	Хашаа байшин	Үйлчилгээний зориулалттай	Үйлдвэрлэлийн зориулалттай	оффис	ферм	Гэр	авто зогсоол	авто гравж, зогсоол	Бусад / өвөлжөө, хаваржаа, хүлэмж, гэх мэт/	Нийт дүн /мян.төг/	Тоо, төрөл	Нийт дүн /мян.төг/	Төрөл, тоо хэмжээ	Нийт дүн /мян.төг/	Зориулалт, тоо, төрөл хэмжээ	Нийт дүн /мян.төг/	Үнэт эдлэл, урлаг, түүхийн үнэт зүйлийн нийт дүн /мян.төг/	Дотоодын банк, санхүүгийн байгууллагад байрлах данс, мөнгөн хөрөнгийн нийт дүн /мян.төг/	Гадаадын банк, санхүүгийн байгууллагад байрлах данс, мөнгөн хөрөнгийн нийт дүн /мян.төг/	Авлагын нийт дүн /мян.төг/	Анх авсан зээлийн нийт хэмжээ /мян.төг/	Хуулийн этгээдийн нэр, хэлбэр	Хувьцааны тоо	Нордол хувь	Эрх, патент, тусгай зөвшөөрлийн төрөл
2	Овог, нэр	Мэдүүлэг гаргагчийн нийт орлого	Аминь орон сууц	Нийтийн орон сууц	Зуслангийн байшин	Хашаа байшин	Үйлчилгээний зориулалттай	Үйлдвэрлэлийн зориулалттай	оффис	ферм	Гэр	авто зогсоол	авто гравж, зогсоол	Бусад / өвөлжөө, хаваржаа, хүлэмж, гэх мэт/	Нийт дүн /мян.төг/	Тоо, төрөл	Нийт дүн /мян.төг/	Төрөл, тоо хэмжээ	Нийт дүн /мян.төг/	Зориулалт, тоо, төрөл хэмжээ	Нийт дүн /мян.төг/	Үнэт эдлэл, урлаг, түүхийн үнэт зүйлийн нийт дүн /мян.төг/	Дотоодын банк, санхүүгийн байгууллагад байрлах данс, мөнгөн хөрөнгийн нийт дүн /мян.төг/	Гадаадын банк, санхүүгийн байгууллагад байрлах данс, мөнгөн хөрөнгийн нийт дүн /мян.төг/	Авлагын нийт дүн /мян.төг/	Анх авсан зээлийн нийт хэмжээ /мян.төг/	Хуулийн этгээдийн нэр, хэлбэр	Хувьцааны тоо	Нордол хувь	Эрх, патент, тусгай зөвшөөрлийн төрөл
3	Албан тушаал	Мэдүүлэг гаргагчийн нийт орлого	Аминь орон сууц	Нийтийн орон сууц	Зуслангийн байшин	Хашаа байшин	Үйлчилгээний зориулалттай	Үйлдвэрлэлийн зориулалттай	оффис	ферм	Гэр	авто зогсоол	авто гравж, зогсоол	Бусад / өвөлжөө, хаваржаа, хүлэмж, гэх мэт/	Нийт дүн /мян.төг/	Тоо, төрөл	Нийт дүн /мян.төг/	Төрөл, тоо хэмжээ	Нийт дүн /мян.төг/	Зориулалт, тоо, төрөл хэмжээ	Нийт дүн /мян.төг/	Үнэт эдлэл, урлаг, түүхийн үнэт зүйлийн нийт дүн /мян.төг/	Дотоодын банк, санхүүгийн байгууллагад байрлах данс, мөнгөн хөрөнгийн нийт дүн /мян.төг/	Гадаадын банк, санхүүгийн байгууллагад байрлах данс, мөнгөн хөрөнгийн нийт дүн /мян.төг/	Авлагын нийт дүн /мян.төг/	Анх авсан зээлийн нийт хэмжээ /мян.төг/	Хуулийн этгээдийн нэр, хэлбэр	Хувьцааны тоо	Нордол хувь	Эрх, патент, тусгай зөвшөөрлийн төрөл
4	Мэдүүлэг гаргагчийн нийт орлого	Мэдүүлэг гаргагчийн нийт орлого	Аминь орон сууц	Нийтийн орон сууц	Зуслангийн байшин	Хашаа байшин	Үйлчилгээний зориулалттай	Үйлдвэрлэлийн зориулалттай	оффис	ферм	Гэр	авто зогсоол	авто гравж, зогсоол	Бусад / өвөлжөө, хаваржаа, хүлэмж, гэх мэт/	Нийт дүн /мян.төг/	Тоо, төрөл	Нийт дүн /мян.төг/	Төрөл, тоо хэмжээ	Нийт дүн /мян.төг/	Зориулалт, тоо, төрөл хэмжээ	Нийт дүн /мян.төг/	Үнэт эдлэл, урлаг, түүхийн үнэт зүйлийн нийт дүн /мян.төг/	Дотоодын банк, санхүүгийн байгууллагад байрлах данс, мөнгөн хөрөнгийн нийт дүн /мян.төг/	Гадаадын банк, санхүүгийн байгууллагад байрлах данс, мөнгөн хөрөнгийн нийт дүн /мян.төг/	Авлагын нийт дүн /мян.төг/	Анх авсан зээлийн нийт хэмжээ /мян.төг/	Хуулийн этгээдийн нэр, хэлбэр	Хувьцааны тоо	Нордол хувь	Эрх, патент, тусгай зөвшөөрлийн төрөл
5	Мэдүүлэг гаргагчийн нийт орлого	Мэдүүлэг гаргагчийн нийт орлого	Аминь орон сууц	Нийтийн орон сууц	Зуслангийн байшин	Хашаа байшин	Үйлчилгээний зориулалттай	Үйлдвэрлэлийн зориулалттай	оффис	ферм	Гэр	авто зогсоол	авто гравж, зогсоол	Бусад / өвөлжөө, хаваржаа, хүлэмж, гэх мэт/	Нийт дүн /мян.төг/	Тоо, төрөл	Нийт дүн /мян.төг/	Төрөл, тоо хэмжээ	Нийт дүн /мян.төг/	Зориулалт, тоо, төрөл хэмжээ	Нийт дүн /мян.төг/	Үнэт эдлэл, урлаг, түүхийн үнэт зүйлийн нийт дүн /мян.төг/	Дотоодын банк, санхүүгийн байгууллагад байрлах данс, мөнгөн хөрөнгийн нийт дүн /мян.төг/	Гадаадын банк, санхүүгийн байгууллагад байрлах данс, мөнгөн хөрөнгийн нийт дүн /мян.төг/	Авлагын нийт дүн /мян.төг/	Анх авсан зээлийн нийт хэмжээ /мян.төг/	Хуулийн этгээдийн нэр, хэлбэр	Хувьцааны тоо	Нордол хувь	Эрх, патент, тусгай зөвшөөрлийн төрөл

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

АЛБАН ТУШААЛТНЫ ... ОНЫ ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛГИЙН ХУРААНГУЙ МЭДЭЭЛЭЛ

201... оны ... дүгээр сарын ...-ний өдөр

Улаанбаатар хот

№	Мэдүүлэг гаргагч		Хувийн ашиг сонирхол					Бэлэг, үйлчилгээ	
	Овог нэр	Албан тушаал	Хамаарал бүхий этгээдийн тоо	Нэгдмэл сонирхолтой этгээдийн тоо	Гишүүнчлэлд байгаа хуулийн этгээд, ТББ-ын нэр	Төлөөлөл хэрэгжүүлсэн тоо	Эх сурвалжийн нэр	Үнэлгээ /мян.төг/	
1	2	3	4	5	6	7	8	9	

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2018 оны 11... сарын 17-ны
өдрийн 4036 дугаарт бүртгэв.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018.11.14

Дугаар А/123

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5, Захиргааны ерөнхий хуулийн 59, 60 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам” / шинэчилсэн найруулга/-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг нийтийн албаны удирдлагуудад, журмыг нийтийн албаны удирдлагуудаас мөрдлөг болгон хэвшүүлэхэд арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлж, сахилгын шийтгэл ногдуулсан талаарх шийдвэр, мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд хүргэсэн талаарх нэгдсэн сан бүрдүүлэн, жил бүр дүнг нэгтгэн танилцуулж байхыг Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс /Эрхэлсэн комиссар Т.Баярхүү/-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тухайн мэдээллийг холбогдох этгээдэд хүргүүлсэн, нийтэд мэдээлсэн нийтийн албаны удирдлагад үүрэг болгосугай.

4. Журмыг баталснаас хойш ажлын 5 өдрийн дотор Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Тамгын хэлтэс /Эрхэлсэн комиссар З.Баасаням/-т даалгасугай.

5. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны 74 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

6. Журмыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР

Х.ЭНХЖАРГАЛ

**АЛБАН ТУШААЛТАН ӨӨРТ НОГДУУЛСАН САХИЛГЫН ШИЙТГЭЛИЙН
ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ ХОЛБОГДОХ ЭТГЭЭД БОЛОН НИЙТЭД ӨӨРИЙН
ЗАРДЛААР ХҮРГЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖУРАМ**
/Шинэчилсэн найруулга/

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар нийтийн албан тушаалтан (цаашид “албан тушаалтан” гэх) Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийг зөрчсөн тохиолдолд мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасан эрх бүхий албан тушаалтан нийтийн албан тушаалтанд хүлээлгэсэн сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг сахилгын зөрчлийн талаар мэдээлэгч, гомдол гаргагч, нийтийн албан тушаалтны хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн бусад этгээд (цаашид “холбогдох этгээд”)-д болон нийтэд өөрийн зардлаар хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү журмыг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан албан тушаалтан, эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасан сахилгын шийтгэл хүлээлгэх эрх бүхий албан тушаалтан дагаж мөрдөнө.

1.3. Албан тушаалтанд ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд хүргэхтэй холбогдон гарах шуудан холбооны зардал, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх үйлчилгээний үнэ, хөлсийг сахилгын шийтгэл хүлээсэн албан тушаалтан хариуцна.

1.4. Сахилгын шийтгэл хүлээлгэсэн тухай мэдээллийг бэлтгэх, холбогдох этгээдэд хүргэх, нийтэд мэдээлэх үүргийг сахилгын шийтгэл ногдуулах шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтан өөрийн байгууллагын Захиргааны асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид хариуцуулна.

1.5. Албан тушаалтанд ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээдэд хүргэх болон нийтэд мэдээлэхтэй холбогдон гарах зардлыг сахилгын шийтгэл хүлээсэн албан тушаалтнаас гаргуулан авах үүргийг энэ журмын 1.4-т дурдсан нэгжийн дарга хариуцан гүйцэтгэнэ.

1.6. Албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэсэн шийдвэрийн талаарх мэдээллийг уг шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор холбогдох этгээдэд хүргэж, нийтэд мэдээлнэ. Мэдээллийг холбогдох этгээдэд хүргэх, нийтэд мэдээлэхэд тухайн албан тушаалтнаас зөвшөөрөл авсан байхыг шаардахгүй.

1.7. Албан тушаалтанд ногдуулсан сахилгын шийтгэл нь шүүхийн шийдвэрээр үндэслэлгүй болох нь тогтоогдсон тохиолдолд мэдээллийг нэн даруй холбогдох этгээдэд хүргэж, нийтэд мэдээлнэ.

Хоёр. Холбогдох этгээдэд хүргэх

2.1. Албан тушаалтан сахилгын зөрчил гаргасан нь тогтоогдож, хууль тогтоомжид заасан шийтгэл хүлээлгэсэн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон тухайн албан тушаалтны харьяалах дээд шатны байгууллагын удирдлагад албан бичгээр хүргүүлнэ.

2.2. Харьяалах дээд шатны байгууллагын удирдлагад хүргүүлэх албан бичигт сахилгын шийтгэл хүлээлгэсэн шийдвэрийн хуулбарыг хавсаргана.

2.3. Хуульд заасан албан тушаалтанд хязгаарласан болон хориглосон хэм хэмжээг зөрчихгүй байх, ашиг сонирхлын зөрчил дахин гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэсэн тухай шийдвэрийг байгууллагын албан хаагчдад танилцуулна.

Гурав. Нийтэд мэдээлэх

3.1. Албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэсэн талаарх мэдээллийг дараахь хэлбэрийн аль нэгээр нийтэд мэдээлнэ.

3.1.1. Орон нутгийн болон үндэсний шинжтэй хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх;

3.1.2. Харьяалах байгууллагын цахим хуудсанд байршуулах;

3.1.3. Мэдээллийн самбарт байршуулах.

3.2. Журмын 3.1.2, 3.1.3-т заасан мэдээллийг Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 48 дугаар зүйлийн 48.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.4 дэх хэсэгт заасан сахилгын шийтгэлгүйд тооцох хугацааг дуустал байршуулна.

3.3. Нийтэд хүргэх мэдээлэлд сахилгын шийтгэл хүлээсэн этгээдийн овог, нэр, байгууллагын нэр, албан тушаал, сахилгын шийтгэл хүлээлгэсэн үндэслэл, сахилгын шийтгэлийн төрлийг тусгана.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан талаарх мэдээллийг холбогдох этгээдэд хүргэсэн болон нийтэд мэдээлсэн өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор журмын 2.1, 3.1-т заасан мэдээллийг тухайн албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэр (хуулбар)-ын хамт эсхүл холбогдох мэдээллийг цахим хэлбэрээр Авлигатай тэмцэх газарт ирүүлнэ.

4.2. Авлигатай тэмцэх газар хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2-т заасан хяналтыг хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зорилгоор эрх бүхий албан тушаалтнуудаас ирүүлсэн мэдээлэл, шийдвэрийг хүлээн авч, нэгдсэн сан үүсгэнэ. Сангийн мэдээлэл олон нийтэд нээлттэй байна.

4.3. Албан тушаалтанд ногдуулсан сахилгын шийтгэл нь шүүхийн шийдвэрээр үндэслэлгүй, эсхүл илт хууль бус акт болох нь тогтоогдсон, эсхүл Захиргааны ерөнхий хуульд зааснаар захиргааны байгууллага өөрөө хүчингүй болгосон, нэмэлт өөрчлөлт оруулсан бол энэ тухай баримтыг, санд өөрчлөлт оруулах саналын хамт ажлын 5 өдрийн дотор Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ.


4.4. Албан тушаалтанд ногдуулсан сахилгын шийтгэл нь шүүхийн шийдвэрээр үндэслэлгүй болох нь тогтоогдсон тохиолдолд энэ тухай журмын 1.4-т дурдсан нэгжээс холбогдох этгээдэд мэдэгдэх ба журмын 1.3-т заасан зардал, үйлчилгээний үнэ, хөлсийг буцаан олгохтой холбоотой асуудлыг Захиргааны ерөнхий хуулийн 101, 103 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

4.5. Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаар холбогдох этгээдэд хүргэх, нийтэд мэдээлэхтэй холбоотой зардлыг гаргаагүй нь мэдээлэл хүргэх, нийтэд мэдээлэхээс татгалзах үндэслэл болохгүй.

ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ БОЛОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙГ ЦАХИМААР МЭДҮҮЛЖ, БАТАЛГААНЫ МАЯГТ БҮРТГҮҮЛЭХ ТУХАЙ


1. Цахим системд нэвтрэх

Нийтийн албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ /цаашид мэдүүлэг гэх / <https://meduuleg.iaac.mn> сайтад нэвтрэн, цахимаар мэдүүлнэ. Үүнд:



2. Мэдүүлэг гаргагчийг цахим системд шинээр бүртгэх

Цахим хэлбэрээр анх удаа мэдүүлгээ гаргаж байгаа албан тушаалтны товч мэдээлэл /регистрийн дугаар, и-мэйл хаяг, байгууллага, албан тушаалын нэр, мэдүүлэг гаргах үндэслэл/-ийг тухайн байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан /цаашид ЭБАТ гэх/-аас бүртгэнэ.



Товч бүртгэл

ХАСХОМ мэдүүлсэн он:	--Сонго--	Регистрийн дугаар:	
Эцэг/эх/-ийн нэр:	Криллээр бичнэ үү!	Нэр:	Криллээр бичнэ үү!
Байгууллагын нэр:	--Сонго--	Албан тушаал:	Криллээр бичнэ үү!
Албан тушаалын ангилал:	--Сонго--	Албан тушаалын зэрэглэл:	--Сонго--
Цахим шуудангийн хаяг:			

Мэдүүлэг гаргах үндэслэл

- Шинээр томилогдсон, сонгогдсон Тухайн жилд нэмэгдсэн шалтгаан: --Сонго--
- Шинэчлэн гаргасан
- Их хэмжээний өөрчлөлт

3. Мэдүүлэг гаргагчийн ХАСХОМ-ийг шилжүүлэн татаж авах

- Мэдүүлэг гаргагчийг бүртгэхэд “ХАСХОМ мэдүүлэгч өөр байгууллагад бүртгэлтэй байна шилжилт хөдөлгөөний хэсгээр ХАСХОМ мэдүүлэгчийг бүртгэнэ үү” гэсэн анхааруулах мессеж гарч байвал тухайн мэдүүлэг гаргагч цахим системд бүртгэлтэй байна гэж үзнэ.

- б. Цахимд бүртгэлтэй мэдүүлэг гаргагчийг урьд өмнө нь бүртгэсэн байгууллагын ЭБАТ-аар “Хасалт” хийлгэнэ. Харин бүртгэх байгууллагын ЭБАТ шилжүүлэн татаж авахдаа “ХАСХОМ мэдүүлэгчийг хайх” хайлтын “Шилжүүлэн татах” –аар орж татаж авна. Мэдүүлгийг шилжүүлэн татаж авахдаа хэдэн оны мэдүүлгийг татаж авахаа сонгож /тухайлбайл 2012, 2012*, 2013, 2013*, 2014, 2014*, 2015, 2015*, 2016, 2016* гэх мэтээс аль нэгийг сонгох/, уг мэдүүлэгт бүртгэлтэй байгаа овог нэр, регисрийн дугаар, и-мэйл хаягийг зөв оруулснаар татаж авах боломжтой болно.

4. Цахим системд нэвтрэх нууц үг

- а/ Цахим системд тухайн байгууллагын ЭБАТ мэдүүлэг гаргачийн товч мэдээлэл /нэгдүгээр хэсэгт зааснаар/-ийг бүртгэснээр түүний и-мэйл хаягаар системээс “нэвтрэх нууц үг” илгээгдэнэ. Цахим системээс “нууц үг”-ийг илгээснээс хойш 24 цагийн дотор нэвтэрсэн байна. Хэрвээ 24 цагийн дотор цахим системд нэвтэрч чадаагүй бол “нууц үг” идэвхигүй болохыг анхаарна уу. Энэ тохиолдолд цахим системийн нүүр хуудсанд байгаа “нууц үг сэргээх холбоос”-ыг дарж холбогдох үйлдлийг хийснээр шинээр “нууц үг” авах боломжтой болно.

ХАСХОМ бүрдүүлэлтийн програмд нэвтрэх таны нууц үг 1725514 болж өөрчилөгдлөө. Та 24 цагийн дотор нэвтэрч нууц үгээ солино уу.

<https://meduuleg.iaac.mn>

Мэдүүлэг авч дуусах хуулийн хугацаа 2 сарын 15.

- б/ Мэдүүлэг гаргагч хэрвээ цахим системд нэвтрэх нууц үгээ мартсан бол “нууц үг сэргээх холбоос”-ыг дарж холбогдох үйлдлийг хийснээр “нууц үг”-ээ шинээр авч болно.

Нэвтрэх нууц үг хүлээн авахгүй байгаа мэдүүлэг гаргагч нарын анхааралд!

Системд ЯАНОО цахим шуудангийн хаягаар бүртгэлтэй мэдүүлэг гаргагч нарт нэвтрэх нууц үг очихгүй байгаа тул мэдүүлэг гаргагч та Албан байгууллагын эсвэл GMAIL хаягаа Эрх бүхий албан тушаалтандаа өгч цахим шуудангийн мэдээллээ шинэчлүүлнэ үү! [GMAIL үүсгэх заавар](#)

Таны цахим системд бүртгэлтэй албан байгууллагын эсвэл GMAIL хаягаар 20-30 минутын хугацаанд цахим шуудан очихгүй бол та Spam фолдер-ийг шалгана уу!


Имэйлээ оруулна уу

Имэйл:

Илгээх

Буцах

- в/ Нууц үг сэргээхэд “Таны нууц үгийг солих боломжгүй. Та дахин оролдоно уу” гэсэн алдааны мессеж гарсан тохиолдолд мэдүүлэг гаргагч байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хандаж өөрийн цахим бүртгэл /и-мэйл/ -ийг шалгуулна.



- И-мэйл хаяг цахимд бүртгэлгүй бол
- Цахимд бүртгүүлсэн и-мэйл хаяг хаагдсан /блок/ бол
- И-мэйл хаягыг цахимд бүртгэхдээ алдаатай бичиж оруулсан бол дээрх алдааны мессеж гарч ирнэ.

5. Мэдүүлэг гаргагч ХАСХОМ-ийг баталгаажуулж баталгааны маягт хэвлэх

